



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 07 сарын 27 өдөр

Дугаар 68

Есөнбулаг сум


2018 онд ойгоос бэлтгэх түлээний  
модны хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/235 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус аймгийн шинэсэн ойд цэвэрлэгээний ажил хийх замаар түлээний мод бэлтгэх сумдын нэр, цэвэрлэгээ хийх талбай, түлээний хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Ойн цэвэрлэгээний ажил явуулах талбайг тусгаарлан, цэвэрлэгээний ажлын явцад технологийн хяналт хийж, холбогдох хууль тогтоомж, журам зааврыг сурталчлан таниулж ажиллахыг Сум дундын ойн ангийн дарга /Б.Эрдэнэбаяр/, цэвэрлэгээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ойг зохих журмын дагуу хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Д.Батмагнай/ нарт тус тус даалгасугай.

3. Цэвэрлэгээний ажлын дүнг 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Д.Батмагнай/, Сум дундын ойн ангийн дарга /Б.Эрдэнэбаяр/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ  
АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2018.07.27

№ 10

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1	Аймгийн Нийтийн номын санг Дэгээхүүгийн Сүрьяагийн нэрэмжит болгох тухай	М. Эрдэнэбилэг	Э. Оюунгэрэл	Тогтоол 60
2	Хороо байгуулах тухай	М. Эрдэнэбилэг		Тогтоол 61
	Алтайн бахархал-2018 хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах тухай	Ш Дэгва	Б Эрдэнэ-Очир	Тогтоол 62
3	"Аймгийн Хүндэт иргэн" цол тэмдгээр шагнах тухай	Б Алтайбаатар	Ч Бат-Эрдэнэ	Тогтоол 63 64 65 66
4	Төрийн дээд шагналд өргөн мэдүүлэх тухай	Б.Алтайбаатар	Ч. Бат-Эрдэнэ	Тогтоол 67
5	Ойн цэвэрлэгээ зохион байгуулах тухай	Б.Эрдэнэбаяр	Б.Нандинцэцэг	Тогтоол 68

ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
АЖЛЫН АЛБА